

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 02 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар А/61 А/40

Улаанбаатар
хот

Заавар, жагсаалтыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5 дахь заалт, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар"-ыг нэгдүгээр, "Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт"-ыг хоёрдугаар, "Өлсгөлөн зарласан үед хөтлөх маягтын загвар"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /Бригадын генерал О.Амарсанаа/, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, сумын нэгдсэн эмнэлгийн дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Төгсдэлгэр/, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Нямгэрэл/-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 233 дугаар тушаалын хавсралтын 1.1 дэх хэсгийн "түүнчлэн хорих анги, цагдан хорих, баривчлах байранд" гэснийг хассугай.



Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 1/140 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАСАН ҮЕД ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хоригдсон этгээд өлсгөлөн зарласан болон сайн дураар хоол тэжээлээс татгалзсан үед эмнэлгийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны гүйцэтгэх үүрэг, эмч, эмнэлгийн мэргэжилтний аюулгүй байдлыг хангах, өлсгөлөн зарласан, сайн дураар хоол тэжээлээс татгалзсан этгээдийн /цаашид "өлсгөлөн зарлагч" гэх/ эрүүл мэндийн байдалд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд албадан хооллох, албадан эмчилгээнд хамруулах үйл ажиллагааг зохицуулахад энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Цагдан хорих төв /байр/-д хоригдсон этгээд өлсгөлөн зарласан үед Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль тэдгээрт нийцүүлэн баталсан журам болон энэхүү зааврыг мөрдөнө.

1.3. Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдэж Баривчлах төв /байр/-д байгаа баривчлагдсан этгээдэд энэ журам хамаарахгүй.

Хоёр. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

2.1. Өлсгөлөн зарлагчид эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ Өвчний олон улсын 10 дугаар ангиллыг баримтална.

- 2.1.1. Өлсгөлөнгийн нөлөө (T73.0)
- 2.1.2. Хоол хүнсний дутагдал, өлсөх (X53)
- 2.1.3. Шингэний дутагдал, цангах (X54)
- 2.1.4. Хоол хүнснээс татгалзах, өлсөх (Y06.9)

2.2. Зорилго

Өлсгөлөн зарлагчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах үүднээс тусламж, үйлчилгээ үзүүлэхэд чиглэнэ.

2.3. Зорилт

- 2.3.1. Өлсгөлөн зарлагчийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, бэлтгэл ажлыг хангах;
- 2.3.2. Өлсгөлөн зарлагчид нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой үзүүлэх;
- 2.3.3. Өлсгөлөн дууссаны дараа дахин хооллолтын зөвлөгөө өгөх, дахин хооллолтын хам шинжээс сэргийлэх;
- 2.3.4. Албадан хооллолт, албадан эмчилгээг оновчтой хийж хяналтыг сайжруулах.

2.4.Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг Нийслэлд Цагдан хорих ангид тус ангийн дарга, орон нутагт нэгдсэн эмнэлгийн дарга /ерөнхий эмч/ томилно.

2.4.1.Эмчилгээ эрхэлсэн орлогч

2.4.2.Дотрын эмч /эмчлэгч эмч/

2.4.3.Сувилагч

2.4.4.Шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмч.

2.5.Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн суурь үнэлгээ хийх

2.5.1.Өлсгөлөн зарлахаар мэдэгдсэн тохиолдолд тухайн өлсгөлөн зарлагчид нийслэлд Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид тус ангийн нэгдсэн эмнэлгийн, орон нутгийн цагдан хорих байранд тухайн байрны эмч эсвэл орон нутгийн нэгдсэн эмнэлгээс томилогдсон эмч эрүүл мэндийн үзлэг, лабораторийн шинжилгээ, суурь үнэлгээг хийж, эрүүл мэндийн хяналтын хуудаст тэмдэглэл үйлдэнэ.

2.5.1.1.Биеийн өндөр, жин, биеийн жингийн индекс /БЖИ/ тодорхойлох;

2.5.1.2.Амин үзүүлэлтийг үзэх (амьсгал тоолох, биеийн халуун хэмжих, судасны лугшилт тоолох, артерийн даралт хэмжих);

2.5.1.3.Цусны болон шээсний ерөнхий, биохимийн дэлгэрэнгүй шинжилгээ хийх.

2.5.2.Шаардлагатай тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг болон нэмэлт шинжилгээг хийнэ.

2.5.2.1.Сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг хийх,

2.5.2.2.Биеийн ерөнхий байдал, эрхтэн тогтолцооны үзлэг хийх,

2.5.2.3.Дараах нэмэлт шинжилгээ /зүрхний цахилгаан бичлэг, уушгины рентген зураг, хэвлийн эхо/-г хийх,

2.5.3.Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалтад заасан өвчин, эмгэг илэрсэн тохиолдолд өлсгөлөн зарлагчид түүний онош болон өлсгөлөн зарлахыг хориглосон тухай эмч, эмнэлгийн комиссын шийдвэрийг бичгээр танилцуулж гарын үсэг зуруулна /Маягт №1/.

2.5.4.Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр өлсгөлөн зарлахад харшлах өвчингүй нь тогтоогдвол, өлсгөлөн зарлагч өлсгөлөнгөөс шалтгаалан бие махбодод учрах хор уршиг, өлсгөлөнгийн үед баримтлах эрүүл ахуйн дэглэмтэй танилцан, эрүүл мэндийн хяналтын хуудсанд гарын үсэг зурсан тохиолдолд бүдүүн гэдсэнд хуримтлагдсан хорт бодисыг гадагшлуулах, бие махбодыг цэвэршүүлэх зорилгоор 4 цагийн зайтай 2 удаа цэвэрлэх бургуй тавьж өлсгөлөн эхлүүлсэнд тооцон тусгаарлах өрөөнд шилжүүлнэ. /Маягт №2/

2.6.Өлсгөлөн зарласны дараа эрүүл мэндийн хяналт тавих

2.6.1.Өлсгөлөн зарлаж эхэлсэн өдрөөс эмч тухайн өлсгөлөн зарлагчид 24 цаг тутамд эрүүл мэндийн үзлэг хийн эрүүл мэндийн хяналтын хуудаст тэмдэглэнэ.

2.6.2.Эрүүл мэндийн нэмэлт үзлэг, шинжилгээнд хамруулах болон шаардлагатай тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тухай сануулгыг

өлсгөлөн зарлагчид танилцуулж, эрүүл мэндийн хяналтын хуудсанд гарын үсэг зуруулна. Татгалзсан тохиолдолд энэ тухай эрүүл мэндийн хяналтын хуудаст тэмдэглэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг"-ийг бөглүүлэн гарын үсэг зуруулна.

2.6.3.Эрт сэрэмжлүүлэх үнэлгээгээр зайлшгүй албадан хооллох болон албадан эмчлэх шаардлагатай бол эмчилгээнээс татгалзсан эсэхээс үл хамааран эмнэлэгт хэвтүүлэн эмчилгээг хийнэ.

2.6.4.Хоол сойх үеийн арга хэмжээний зөвлөмж

Хүснэгт 1. Хоол сойх үеийн арга хэмжээний зөвлөмж

Өдөр	<u>Ерөнхий зөвлөмж:</u>
Өлсгөлөн зарласан эхний өдөр	<ul style="list-style-type: none"> - Өлсгөлөн зарлагчийн биеийн байдалд өөрчлөлт илэрвэл нийслэлд Цагдан хорих ангийн захиргаа нь тус ангийн нэгдсэн эмнэлэгт, орон нутгийн цагдан хорих байрны захиргаа нь орон нутгийн нэгдсэн эмнэлэгт мэдээлнэ. - Өлсгөлөн зарлагчид өдөрт 1-1.5 л шингэн уухыг зөвлөнө. - Өлсгөлөн, хоол сойх, дахин хооллолтын талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө. - Яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд эмнэлэгт шилжүүлнэ. <p><u>Хяналт:</u> Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй баг өдөр болгон хянаж, тусламж шаардлагатай эсэхийг тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - харж ажиглах; - ярилцлага хийх; - бодит үзлэг хийх.
Өлсгөлөн зарласнаас хойш 2-5 дахь өдөр	<ul style="list-style-type: none"> - Өлсгөлөн зарлагчийн биеийн байдалд өөрчлөлт илэрвэл нийслэлд Цагдан хорих ангийн захиргаа нь тус ангийн нэгдсэн эмнэлэгт, орон нутгийн цагдан хорих байрны захиргаа нь орон нутгийн нэгдсэн эмнэлэгт мэдээлнэ. - Өлсгөлөн зарлагчид өдөрт 1-1.5 л шингэн уухыг зөвлөнө. - Өлсгөлөн, хоол сойх, дахин хооллолтын талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө. - Яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд эмнэлэгт шилжүүлнэ. Эмчилгээнээс татгалзсан үед "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг" маягтыг бөглүүлэн гарын үсгээр баталгаажуулна. - Эмнэлгийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тохиолдолд албадан эмчилгээг хийнэ. - Байнгын эм хэрэглэдэг өлсгөлөн зарлагчид хүндрэл, эрсдэл үүсвэл төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөмжийн дагуу эмийн тунг багасгах эсвэл зогсоох арга хэмжээ авна. - Сэтгэцийн талаас эмгэг шинж илэрвэл сэтгэцийн эмчид үзүүлнэ. <p><u>Хяналт:</u> Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй баг өдөр болгон хянаж, тусламж шаардлагатай эсэхийг тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - харж ажиглах;

	<ul style="list-style-type: none"> - ярилцлага хийх; - бодит үзлэг хийх. <p>Эмнэлзүйд үндэслэн эрсдэл үүсвэл дараах үзлэг, шинжилгээг хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - амин үзүүлэлт, биеийн жин, БЖИ тодорхойлох, - лабораторийн шинжилгээнд: цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохими, шээсний ерөнхий шинжилгээ хийх; - нэмэлт шинжилгээнд: зүрхний цахилгаан бичлэг, уушгины рентген зураг, хэвлийн эхо хийх;
<p>Өлсгөлөн зарласнаас хойш 6-10 дахь өдөр</p>	<p><u>Ерөнхий зөвлөмж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Өлсгөлөн зарлагчийн биеийн байдалд өөрчлөлт илэрвэл нийслэлд Цагдан хорих ангийн захиргаа нь тус ангийн нэгдсэн эмнэлэгт, орон нутгийн цагдан хорих байрны захиргаа нь орон нутгийн нэгдсэн эмнэлэгт мэдээлнэ. - Өлсгөлөн зарлагчид өдөрт 1-1.5 л шингэн уухыг зөвлөнө. - Өлсгөлөн, хоол сойх, дахин хооллолтын талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө. - Шингэний дутагдалд орох, сэтгэцийн өөрчлөлт илрэх, бие махбодод бусад өөрчлөлт илэрч зайлшгүй тусламж, үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлно. - Яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд эмнэлэгт шилжүүлнэ. Эмчилгээнээс татгалзсан үед “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг” маягыг бөглүүлэн гарын үсгээр баталгаажуулна. - Эмнэлгийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тохиолдолд албадан эмчилгээг хийнэ. - Байнгын эм хэрэглэдэг өлсгөлөн зарлагчид хүндрэл, эрсдэл үүсвэл төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөмжийн дагуу эмийн тунг багасгах эсвэл зогсоох арга хэмжээ авна. - Сэтгэцийн талаас эмгэг шинж илэрвэл сэтгэцийн эмчид үзүүлнэ. <p><u>Хяналт:</u></p> <p>Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй баг өдөр болгон хянаж, тусламж шаардлагатай эсэхийг тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - харж ажиглах; - ярилцлага хийх; - бодит үзлэг хийх. <p>Эмнэлзүйд үндэслэн эрсдэл үүсвэл дараах үзлэг, шинжилгээг хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - амин үзүүлэлт, биеийн жин, БЖИ тодорхойлох, - лабораторийн шинжилгээнд: цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохими, шээсний ерөнхий шинжилгээ хийх; - нэмэлт шинжилгээнд: зүрхний цахилгаан бичлэг, уушгины рентген зураг, хэвлийн эхо хийх;
<p>Өлсгөлөн зарласнаас хойш 11-20 дахь өдөр</p>	<p><u>Ерөнхий зөвлөмж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Өлсгөлөн зарлагчийн биеийн байдалд өөрчлөлт илэрвэл нийслэлд Цагдан хорих ангийн захиргаа нь тус ангийн нэгдсэн эмнэлэгт, орон нутгийн цагдан хорих байрны захиргаа нь орон нутгийн нэгдсэн эмнэлэгт мэдээлнэ. - Өлсгөлөн зарлагчид өдөрт 1-1.5 л шингэн уухыг зөвлөнө. - Өлсгөлөн, хоол сойх, дахин хооллолтын талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө.

	<ul style="list-style-type: none"> - Шингэний дутагдалд орох, сэтгэцийн өөрчлөлт даамжрах, бие махбодод бусад өөрчлөлт илэрч зайлшгүй тусламж, үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлно. - Яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд эмнэлэгт шилжүүлнэ. Эмчилгээнээс татгалзсан үед “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг” маягыг бөглүүлэн гарын үсгээр баталгаажуулна. - Эмнэлгийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тохиолдолд албадан эмчилгээг хийнэ. - Байнгын эм хэрэглэдэг өлсгөлөн зарлагчид хүндрэл, эрсдэл үүсвэл төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөмжийн дагуу эмийн тунг багасгах эсвэл зогсоох арга хэмжээ авна. - Сэтгэцийн талаас эмгэг шинж даамжирвал эмнэлзүйд суурилан тухай бүрд сэтгэцийн эмчийн үзлэг хийнэ. <p><u>Хяналт:</u> Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй баг өдөр болгон хянаж, тусламж шаардлагатай эсэхийг тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - харж ажиглах; - ярилцлага хийх; - бодит үзлэг хийх. <p>Эмнэлзүйд үндэслэн эрсдэл үүсвэл дараах үзлэг, шинжилгээг хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - амин үзүүлэлт, биеийн жин, БЖИ тодорхойлох, - лабораторийн шинжилгээнд: цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохими, шээсний ерөнхий шинжилгээ хийх; - нэмэлт шинжилгээнд: зүрхний цахилгаан бичлэг, уушгины рентген зураг, хэвлийн эхо хийх;
<p>Өлсгөлөн зарласнаас хойш 21-30 дахь өдөр</p>	<p><u>Ерөнхий зөвлөмж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Өлсгөлөн зарлагчийн биеийн байдалд өөрчлөлт илэрвэл нийслэлд Цагдан хорих ангийн захиргаа нь тус ангийн нэгдсэн эмнэлэгт, орон нутгийн цагдан хорих байрны захиргаа нь орон нутгийн нэгдсэн эмнэлэгт мэдээлнэ. - Өлсгөлөн зарлагчид өдөрт 1-1.5 л шингэн уухыг зөвлөнө. - Өлсгөлөн, хоол сойх, дахин хооллолтын талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө. - Шингэний дутагдалд орох, сэтгэцийн өөрчлөлт даамжрах, бие махбодод бусад өөрчлөлт илэрч зайлшгүй тусламж, үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлно. - Яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд эмнэлэгт шилжүүлнэ. Эмчилгээнээс татгалзсан үед “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг” маягыг бөглүүлэн гарын үсгээр баталгаажуулна. - Эмнэлгийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тохиолдолд албадан эмчилгээг хийнэ. - Байнгын эм хэрэглэдэг өлсгөлөн зарлагчид хүндрэл, эрсдэл үүсвэл төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөмжийн дагуу эмийн тунг багасгах эсвэл зогсоох арга хэмжээ авна. - Сэтгэцийн талаас эмгэг шинж даамжирвал эмнэлзүйд суурилан тухай бүрд сэтгэцийн эмчийн үзлэг хийнэ. - Өлсгөлөн зарлагчид лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ шаардлагатай эсэхийг /биеийн жингээ 15%-иас дээш алдсан

	<p>эсвэл БЖИ 19 кг/м²-ээс багассан/ тодорхойлно.</p> <p><u>Хяналт:</u> Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй баг өдөр болгон хянаж, тусламж шаардлагатай эсэхийг тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - харж ажиглах; - ярилцлага хийх; - бодит үзлэг хийх. <p>Эмнэлзүйд үндэслэн эрсдэл үүсвэл дараах үзлэг, шинжилгээг хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - амин үзүүлэлт, биеийн жин, БЖИ тодорхойлох, - лабораторийн шинжилгээнд: цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохими, шээсний ерөнхий шинжилгээ хийх; - нэмэлт шинжилгээнд: зүрхний цахилгаан бичлэг, уушгины рентген зураг, хэвлийн эхо хийх;
<p>Өлсгөлөн зарласнаас хойш 31-ээс дээш өдөр</p>	<p><u>Ерөнхий зөвлөмж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Өлсгөлөн зарлагчийн биеийн байдалд өөрчлөлт илэрвэл нийслэлд Цагдан хорих ангийн захиргаа нь тус ангийн нэгдсэн эмнэлэгт, орон нутгийн цагдан хорих байрны захиргаа нь орон нутгийн нэгдсэн эмнэлэгт мэдээлнэ. - Өлсгөлөн зарлагчид өдөрт 1-1.5 л шингэн уухыг зөвлөнө. - Өлсгөлөн, хоол сойх, дахин хооллолтын талаар мэдээлэл, зөвлөгөө өгнө. - Шингэний дутагдалд орох, сэтгэцийн өөрчлөлт даамжрах, бие махбодод бусад өөрчлөлт илэрч зайлшгүй тусламж, үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлж албадан эмчилгээ хийнэ. - Яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд эмнэлэгт шилжүүлнэ. Эмчилгээнээс татгалзсан үед “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг” маягыг бөглүүлэн гарын үсгээр баталгаажуулна. - Байнгын эм хэрэглэдэг өлсгөлөн зарлагчид хүндрэл, эрсдэл үүсвэл төрөлжсөн мэргэшлийн эмчийн зөвлөмжийн дагуу эмийн тунг багасгах эсвэл зогсоох арга хэмжээ авна. - Сэтгэцийн талаас эмгэг шинж даамжирвал эмнэлзүйд суурилан тухай бүрд сэтгэцийн эмчийн үзлэг хийнэ. - Өлсгөлөн зарлагчид лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ шаардлагатай эсэхийг /биеийн жингээ 15%-иас дээш алдсан эсвэл БЖИ 19 кг/м²-ээс багассан/ тодорхойлно. <p><u>Хяналт:</u> Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй баг өдөр болгон хянаж, тусламж шаардлагатай эсэхийг тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - харж ажиглах; - ярилцлага хийх; - бодит үзлэг хийх. <p>Эмнэлзүйд үндэслэн эрсдэл үүсвэл дараах үзлэг, шинжилгээг хийнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - амин үзүүлэлт, биеийн жин, БЖИ тодорхойлох, - лабораторийн шинжилгээнд: цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохими, шээсний ерөнхий шинжилгээ хийх; - нэмэлт шинжилгээнд: зүрхний цахилгаан бичлэг, уушгины рентген зураг, хэвлийн эхо хийх;

2.7. Өлсгөлөнгийн улмаас бие махбодод гарах өөрчлөлт

Хүснэгт 2. Өлсгөлөнгийн улмаас бие махбодод гарах өөрчлөлт

Өлсгөлөнгийн үед хангалттай шингэн хэрэглэж байгаа тохиолдолд 2 долоо хоног хүртэл сайн дасан зохицолтой байна. Хоногт биеийн жин 1-2 кг буурна.	
Өлсгөлөн зарласнаас хойш 1-5 дахь өдөр	<ul style="list-style-type: none"> - Өлсөх мэдрэмж, ходоод зангирах шинжүүд 2-3 өдрөөс арилна. - Глюкозын түвшин буурна. Глюкагоны ялгарал нэмэгдэж инсулин багасна. - Глюкагоны нөөцөөр глюкозын түвшинг барих ба энэ ховор тохиолдолд 72 цагаас дээш хугацаанд барих боломжтой.
Өлсгөлөн зарласнаас хойш 6-10 дахь өдөр	<ul style="list-style-type: none"> - Тархи болон цусны улаан эсэд энергийн эх үүсвэр болох глюкоз шаардагдана. - Глюкагоны нөөцгүй болсноос бусад үүсвэрээс /булчингийн уураг, глюконеогенез/ глюкоз хангагдана. - Өөхний хүчлийн задралаас бусад эд, эрхтнийг энергиэр хангана. - Биеийн өөхлөг, булчин болон эрдсийн /кали, фосфор, магни гэх мэт/ хэмжээ буурна. - Сийвэнгийн эрдэс эсийн доторх эрдсийн нөөцөөр нөхөгдөнө.
Өлсгөлөн зарласнаас хойш 11-20 дахь өдөр	<ul style="list-style-type: none"> - Толгой эргэх, ухаан балартах, зогсож чадахгүй болох, даарах, толгой хоосон оргиж дүйнгэтэх, бие сулрах, цангах мэдрэмж алга болох шинжүүд илэрнэ. - Бодит үзлэгт: хүнд хэлбэрийн атакси, брадикарди, ортостатик гипотензи. - Шингэний байдлыг хянах, ихээр шингэн сэлбэснээс гипокалиемид хүргэх аюултай. - Өлсгөлөнгийн 2-3 дахь долоо хоногоос тиамины дутагдал илэрнэ. - Энэ үед биеийн жин өдөрт 0.3 кг-аар буурна.
Өлсгөлөн зарласнаас хойш 21-30 дахь өдөр	<ul style="list-style-type: none"> - Хамгийн хүнд үе шат бөгөөд тиамины дутагдлын шинжүүд тод илэрнэ. - Тиамины дутагдлаас нүдний булчингийн саажил үүсэж окуломотор шинж гарна. /хяналтгүй нистагм, диплопи, вертиго, бөөлжих гэх мэт/ - Ус залгихад хүндрэлтэй болно. - Биеийн жин $\geq 18\%$ алдагдана.
Өлсгөлөн зарласнаас хойш 31-ээс дээш өдөр	<ul style="list-style-type: none"> - Бие сулрах, ядрах шинж даамжирна. <ul style="list-style-type: none"> • Ухаан балартах, ой муудах • Төвлөрч чадахгүй болох • Нойрмоглох, орчноо мэдрэхгүй болох - Аюултай хүндрэлийн шинжүүд: <ul style="list-style-type: none"> • Юм сонсохгүй, харахгүй болох • Геморрагийн шинж: шүд буйл, улаан хоолой, ходоод гэдэс - Эрхтний үйл ажиллагаа алдагдах: хүнд хэлбэрийн брадикарди, Чейн Стоксын амьсгал, бүх метаболизм алдагдах - Биеийн жин $\geq 30\%$ алдагдахад амь насанд аюултай болно - Зүрх судасны коллапс эсвэл ховдлын аюултай хэм алдагдлын улмаас нас барна. - Ховор тохиолдолд дархлаа тогтолцоо суларснаас сепсис болж сүүн хүчлийн ацидоз, нарийн гэдэсний түгжрэл, олон эрхтний дутагдал нь үхлийн шалтгаан болно.

2.8.Эмчилгээ, хооллолт

2.8.1.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх баг нь өлсгөлөн зарлагчийг өдөр бүр ажиглаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай эсэхийг тодорхойлно.

2.8.2.Өлсгөлөн зарлагчийн эрүүл мэнд, дахин хооллолтын үеийн хам шинжийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

2.8.3.Өлсгөлөн зарлагчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмнэлгээс дараах арга хэмжээг авна.

2.8.3.1.Өндөр эрсдэлтэй хүн (эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн) өлсгөлөн зарласан тохиолдолд өлсгөлөнгөөс шалтгаалсан хүндрэл, дахин хооллолтын үеийн хам шинж үүсэх эрсдэлтэй эсэхийг тодорхойлно.

2.8.3.2.Өндөр эрсдэлтэй хүн өлсгөлөн зарласан тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмчид үзүүлж, зөвлөмж авна.

2.8.3.3.Өндөр эрсдэлтэй хүн өлсгөлөн зарласан тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээнээс татгалзвал эрүүл мэндийн хяналтын хуудаст тэмдэглэнэ.

2.8.3.4.Өндөр эрсдэлтэй өлсгөлөн зарлагч төрөлжсөн мэргэшлийн эмчийн заавраар эм хэрэглэдэг бол түүний шийдвэрээр эмийн тунг бууруулах эсвэл зогсооно.

2.8.3.5.Өндөр эрсдэлтэй өлсгөлөн зарлагч төрөлжсөн мэргэшлийн эмчийн заавраар эм хэрэглэж байх үед эмийн гаж нөлөө илэрсэн тохиолдолд мэдээллийг тухайн эмчид бичгээр хүргүүлнэ.

2.8.3.6.Өндөр эрсдэлтэй өлсгөлөн зарлагчийг сэтгэцийн эмчид үзүүлнэ.

2.8.4.Өлсгөлөн зарлагч зохистой орчинд байгаа эсэхийг эмч тодорхойлно.

2.8.5.Дахин хооллолтын хам шинжийн эрсдэлээс сэргийлнэ.

2.8.5.1.Дахин хооллолтын хам шинжийн бага эрсдэлийн үед өлсгөлөн зарлагчид тусгайлсан анхаарал шаардлагагүйгээр идэж, ууж болно.

2.8.5.2.Дахин хооллолтын хам шинжийн дунд эрсдэлийн үед эхний 48 цагт эмнэлгийн тусламж, үйлчилгээний багийн зөвлөмжийн дагуу хоолны дэглэмийг баримтална.

2.8.5.3.Дахин хооллолтын хам шинжийн өндөр эрсдэлийн үед эмнэлэгт хэвтүүлэн дахин хооллох үйл ажиллагааг зохион байгуулна. Хоолыг долоо хоногт 10 ккал/кг/өдрөөс 30 ккал/кг/өдөр болтол аажим нэмнэ. Өлсгөлөн зарлагчид шингэний баланс алдагдах, эрдэс ба зүрх, судасны өөрчлөлт гарч болзошгүй тул хянаана.

2.8.5.4.Дахин хооллолтын хам шинжийн эрсдэл

Хүснэгт 3. Дахин хооллолтын хам шинжийн эрсдэл

Бага зэргийн эрсдэл	Дунд зэргийн эрсдэл	Өндөр эрсдэл
<ul style="list-style-type: none">• 15-аас доош өдөр өлсгөлөн зарласан бол,• Өлсгөлөн зарласантай холбоотой хүндрэл	<ul style="list-style-type: none">• Ямар нэгэн хавсарсан өвчтэй бол,• БЖИ>16, өлсгөлөнгийн үед $\leq 18.5\text{кг}/\text{м}^2$ бол,	<ul style="list-style-type: none">• БЖИ $\leq 16\text{кг}/\text{м}^2$ бол,• Хоолноос татгалзсанаас хойш биеийн жингийн $> 15\%$ алдагдсан бол,

гараагүй бол.	<ul style="list-style-type: none"> • 15-30 өдөр хоолноос татгалзсан бол. 	<ul style="list-style-type: none"> • Хооллохын өмнө цусанд кали, магни эсвэл фосфат бага бол, • 31-ээс илүү олон өдөр хоолноос татгалзсан бол, • Бие махбодын болон сэтгэцийн эмгэг илэрч хүндрэл үүссэн бол.
---------------	---	--

2.8.5.5. Дахин хооллолтын хам шинж

Хүснэгт 4. Дахин хооллолтын хам шинж

<p>Тодорхойлолт:</p> <ul style="list-style-type: none"> - Өлсгөлөнгийн байдалд удаан хугацаагаар байсны дараа хоол, тэжээл хэрэглэхтэй холбоотой илрэх бодисын солилцооны өөрчлөлт, - Биохимийн болон эмнэлзүйн маш их өөрчлөлт илэрдэг тул олон улсад нэгдсэн нэг ойлголт байдаггүй, - Гипофосфатиемийн шинж нь оношилгооны гол үзүүлэлт гэж авч үзэх тохиолдол цөөнгүй, - Олон эрхтний дутагдал ялангуяа, бөөрний дутагдалтай холбоотой сийвэнгийн фосфорын хэмжээ буурахгүй байдаг.
<p>Физиологийн өөрчлөлт:</p> <ul style="list-style-type: none"> - Өлсгөлөнгийн дараа хоол унд, идсэнтэй холбоотой инсулин огцом ихээр ялгарснаас глюконеогенез болон анаэробик метаболизм эрс буурна. - Инсулин ихээр ялгарснаас эсийн гаднах кали, фосфор, магни эсийн дотор шилжиж эсийн гаднах эрдсийн хэмжээ огцом буурна. - Нүүрс уснаас хамааралтай солилцоо эрчимжихэд тиамины хэрэгцээ нэмэгдэнэ.
<p>Эмнэл зүй:</p> <ul style="list-style-type: none"> - Илрэх шинжүүд олон янз, дээрх шинжүүд заримдаа хожуу илэрч болно. - Сийвэнгийн эрдсийн өөрчлөлтөөс зүрх, мэдрэл, араг ясны булчингийн эсийн мембраны үйл ажиллагааны алдагдал илэрнэ. - Биохимийн, эрдсийн өөрчлөлт хэр их байгаагаас эмнэлзүйд илрэх шинж хамаарна. - Эрдсийн бага өөрчлөлтийн үед эмнэлзүйн шинж тэмдэг илрэхгүй байж болно. - Зонхилон илрэх шинжүүд нь: огиулж, бөөлжих, нойрмоглох, амьсгал, зүрх судасны дутагдал, гипотензи, хэм алдагдал, ухаан самуурах зэрэг шинж тэмдэг илэрч комын байдалд орж үхэлд хүрч болно. - Эрдсийн их өөрчлөлтийн үед эмнэлзүйн өөрчлөлт хурдан илэрнэ. - Сийвэнгийн альбумины хэмжээ бага байх нь гипофосфатиемийн урьдал үе болно.

2.9. Өлсгөлөн зогсоох, өлсгөлөнгийн дараа дахин хооллолт

Өлсгөлөн зарлагчид албадан хооллолт, албадан эмчилгээний талаар бичгээр /цаашид гарах хүндрэлээс сэргийлэх/ мэдээллийг танилцуулан гарын үсэг зуруулна.
/Маягт №3/

2.9.1. Өлсгөлөнг дараах байдлаар зогсооно.

- Өөрийн хүсэлтээр зогсоох
- Албадан зогсоох: тухайн хүнд амь насанд аюултай эмнэлзүйн

шинжүүд илэрч байгаа тохиолдолд албадан хооллох, албадан эмчилгээнд оруулна.

2.9.2. Өлсгөлөнгийн байдалд удаан хугацаанд байсны дараа хоол, тэжээл хэрэглэхтэй холбоотой бодисын солилцоо, биохимийн болон эмнэлзүйн маш их өөрчлөлт илэрдэг тул уг хам шинжийн эрсдэлийг тооцоолно.

2.9.3. Дахин хооллох хам шинжийн эрсдэлийг дараах үзүүлэлтийг үндэслэн тооцоолно:

- Биеийн жингийн индекс /БЖИ/ тодорхойлно;
- Биеийн жин нь өлсгөлөн зарласан эхний өдрийнхөөс хэдэн хувиар буурсан байдал;
- Хавсарсан өвчтэй эсэх;
- Өлсгөлөн зарласан хугацааг тооцно.

2.9.4. Дахин хооллолтын хам шинжийн эмчилгээний ерөнхий зарчим

- Эмийн хэрэглээний эрсдэлийг үнэлэх;
- Өндөр эрсдэлтэй өвчнийг эрт илрүүлэх;
- Хооллохоос өмнө лабораторийн шинжилгээ хийх;
- Биохими, эрдсийн шинжилгээний өөрчлөлтийг хэвийн хэмжээнд оруулах;
- Дахин хооллолтын хам шинжийн эрсдэл үүсэхээс сэргийлэх;
- Зохистой хооллолтын аргачлалыг сонгох.

2.9.5. Дахин хооллолтын хам шинжийн эрсдэлтэй үеийн зөвлөмж

2.9.5.1. Дахин хооллолтын хам шинжийн бага эрсдэлийн үед өлсгөлөн зарлагчид 15-аас бага өдөр өлсгөлөн зарласан бол (архаг өвчингүй, БЖИ > 18.5 кг/м²) онцгой хяналт шаардлагагүй.

• Өлсгөлөн зарлагч олон өдөр шингэнээс татгалзсан бол амаар болон судсаар шингэнийг нөхөхдөө бөөрний үйл ажиллагааны өөрчлөлтийг илрүүлэх шинжилгээ /цус, шээсний ерөнхий, биохими, хэвлийн хэт авиан/- г хийнэ.

• Хүссэнээрээ ууж, идэж болох ба дахин хооллолтын хам шинж илрэхээс сэргийлэх шаардлагагүй.

2.9.5.2. Дахин хооллолтын хам шинжийн дунд эрсдэлийн үед өлсгөлөн зарлагчид (архаг хууч өвчинтэй эсвэл суурь БЖИ ≤ 18.5 кг/м²) дараах шалгуураас нэгийг хангасан бол онцгой анхаарна.

• БЖИ 16-18.5 кг/м² хооронд байх;

• Өлсгөлөн зарласан үеэс хойш биеийн жингээ > 10-15%-иар алдсан бол;

• 15-30 өдрийн турш өлсгөлөн зарласан бол;

• Хоолны илчлэгийг зохистой тооцоолох (эхний 2 өдөрт ≤ 20 ккал/кг/өдөр тун, эхний 48 цагт ямар нэгэн өөрчлөлт илрээгүй бол дараагийн 2 өдөрт эмчилгээний хоолны стандартаар хооллох ба цаашид хязгаарлахгүйгээр энгийн хоолны дэглэмд оруулна).

• Амаар шингэнийг ойролцоогоор 30 мл/кг/өдөр байхаар тооцоолох (шингэн дутагдлын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн эсвэл цусны шинжилгээгээр шээг/креатинины харьцаа өөрчлөлттэй байвал уух шингэнийг 2 дахин нэмнэ).

2.9.5.3. Дахин хооллолтын хам шинжийн өндөр эрсдэлтэй үед өлсгөлөн зарлагчид дараах шинж илэрдэг. Энэ тохиолдолд 24 цагийн сувिलाхуйн хяналтад

байлгах, өдөр бүр лабораторийн шинжилгээ хийх, дахин хооллолтын зохистой аргачлалыг гаргаж, мөрдөнө.

Дахин хооллолтын хам шинжийн өндөр эрсдэлтэй үеийг дараах байдлаар тодорхойлно.

- БЖИ $<16\text{кг}/\text{м}^2$ байх;
- Өлсгөлөн зарласнаас хойш биеийн жингээ $>15\%$ -иар алдсан бол;
- Хооллохоос өмнө цусанд кали, магни, фосфат бага байх;
- 31-ээс дээш өдөр өлсгөлөн зарласан бол;
- Сэтгэцийн өөрчлөлт илэрсэн болон хавсарсан өвчтэй бол;

Дахин хооллолтын хам шинжийн өндөр эрсдэлтэй үеийн хяналт:

- Хооллолтоос өмнө цусанд кали, магни, фосфат, натри, кальци, глюкоз, шээг, креатинин үзэж, 3 өдрийн дараа давтан хянах;
- Хооллолтоос өмнө элэгний үйл ажиллагаа үзэж, 7 өдрийн дараа давтан хянах;
- Хооллолтоос өмнө зүрхний бичлэг, хэвлийн хэт авиан шинжилгээ хийж, 7 өдрийн дараа давтан хянах;
- Электролитүүд хэвийн эсвэл их байх нь дахин хооллолтын хам шинжийн эрсдэлийг бууруулахгүй (бие организмд электролитийн дутагдал үүссэн байх магадлалтай)
- Шингэний ихдэлт, ямар нэгэн халдварын шинж тэмдэг илрэх, биеийн ерөнхий байдал муудах үед гарч болох өөрчлөлтийг ажиглах.

Дахин хооллолтын хам шинжийн өндөр эрсдэлтэй үеийн хооллолт:

- Хоолны илчлэгийг зохистой тооцоолох (эхний 24 цагт 5 ккал/кг/өдөр хооллож, хэрэв дараагийн өдөр ямар нэгэн өөрчлөлт илрээгүй бол өдөрт 5-10 ккал/кг/өдөр хэмжээгээр нэмэгдүүлж, цаашид өдөрт 34-40 ккал/кг/хоног хэмжээгээр нэмэгдүүлж, 5-7 өдрийн дараагаас хязгаарлахгүйгээр хооллоно);
- Хэрэв өвчтөн амаар хооллоход тохиромжгүй бол хамар амын гуурсаар хооллоно;
- Хоол хүнс нь 1 ккал/мл байх ба өдрийн хэмжээ 300-400 мл байна;
- Шингэнийг өдөрт 30 мл/кг/хоногоос хэтрүүлэхгүй (хэрэв шингэн алдалт эмнэлзүйгээр эсвэл цусанд шээг/креатинины харьцаа өөрчлөгдсөн бол шингэнийг нэмж болно. Шингэний балансыг "тэг" болгох. Жишээ нь: $170\text{ см өндөртэй хүн} = 70\text{ кг} * 30\text{ мл/кг} = 2100\text{ мл шингэн авна}$)
- Мультивитамин болон элементийг нэмэлтээр өгөх (тиамин 100 мг өдөрт 1 удаа 7 хоног уух, "В" комплекс өдөрт 1 удаа 7 хоног уух, мультивитамин өдөрт 1 удаа 60 хоног уух)
- Эрдсийн нэмэлт бүтээгдэхүүн заавал өгөх (суурь хэмжээ хэвийн ч гэсэн кали, фосфат, магни хүснэгт 5-т зааснаар уулгана. Электролитийн дутал, бөөрний дутагдалтай үед (сийвэн дэх электролитийн түвшин өндөр) бөөрний үйл ажиллагааг хэвийн болтол дахин хооллох, шингэн нөхөх эмчилгээг хийнэ).
- Эмчилгээний үр дүнд биеийн байдал тогтворжиж, шинжилгээний үзүүлэлт хэвийн болсон бол эмнэлгээс гаргана.

2.9.5.4. Өндөр эрсдэлтэй тохиолдолд шингэн, тэжээлийг тохируулах

Хүснэгт 5. Өндөр эрсдэлтэй тохиолдолд шингэн, тэжээлийг тохируулах

Хоног	Илчлэг	Хяналт, эмчилгээний нэмэлт
Хооллолтын	Маш хүнд үед:	Эрдсийн нэмэлт:

эхний өдөр	5 ккал/кг/хоног Бусад тохиолдолд: 10 ккал/кг/хоног Хоолны найрлага: - Нүүрс ус: 50-60% - Өөх тос: 30-40% - Уураг: 15-20%	- Фосфор 0.5-0.8 ммоль/кг/хоногт - Кали 1-3 ммоль/кг/хоногт - Магни 0.3-0.4 ммоль/кг/хоногт - Натри < 1 ммоль/кг/хоногт Судсаар хийх шингэнийг хязгаарлана. - "тэг" шингэний баланс болгох Витамин: - Хооллохоос 30 минутын өмнө тиамин 300 мг + витамин "В" комплекс судсаар хийнэ. Зүрх судас, лабораторийн хяналт тогтмол хийнэ.
2-4 хоног	Дасан зохицол сайн байвал илчлэгийг 5 ккал/кг/хоног-оор нэмэгдүүлнэ.	- Биохимийн хяналт шинжилгээнд илэрч байгаа өөрчлөлтийг засах. - Тиамин 300 мг + витамин "В" комплексыг уухаар эсвэл судсаар 3 өдөр хийнэ. - Зүрх судас, лабораторийн хяналт тогтмол хийнэ.
5-7 хоног	- Илчлэгийг 20-30 ккал/кг/хоног хүртэл нэмнэ. - Хэрэв дасан зохицол муу байвал илчлэгийг нэмэхгүй, шаардлагатай бол бууруулж болно.	- Зүрх судас, бөөр, элэгний үйл ажиллагаа, лабораторийн хяналт тогтмол хийнэ. - Судсаар хийх шингэнийг хязгаарлана. /"тэг" шингэний баланс болгох/ Эрдсийн нэмэлт: - 7 дахь өдрөөс төмрийн бэлдмэл өгнө.
8-10 хоног	- Илчлэгийг 30 ккал/кг/хоног хүртэл нэмнэ. - Шаардлагатай эрдэс тэжээлийг өгөх	Зүрх судас, лабораторийн хяналт тогтмол хийнэ.
<p>Хооллолттой холбоотой хам шинж үүсэх өндөр эрсдэл:</p> <ul style="list-style-type: none"> - Өлсгөлөн зарласнаас хойш 28-аас дээш хоносон бол, - БЖИ <16 кг/м2 бол, - Биеийн жингээ >15%-иар алдсан бол, - Цусанд кали, фосфор, магнийн түвшин багассан бол, - Эмнэл зүйн эмгэг шинж тэмдэг, сэтгэцийн өөрчлөлт илэрсэн бол 		

2.10. Хяналт болон эмчилгээг зогсоох

Өлсгөлөнг зогсоосны дараа, албадан эмчилгээний дараа өлсгөлөн зарлагчийн биеийн байдлыг "Эрт сэрэмжлүүлэх үеийн үнэлгээ" аргачлалаар үнэлнэ. Үнэлгээний нийлбэр оноо 4-өөс бага, биеийн байдал тогтвортой, цаашид ердийн байдлаар хооллох боломжтой бол эмнэлгийн тусламж, үйлчилгээний баг эрүүл мэндийн хяналтын хуудаст тэмдэглэж, цаашдын зөвлөгөө өгч, өлсгөлөнгийн үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг зогсооно. /Маягт №4/

2.11. Эрт сэрэмжлүүлэх үеийн үнэлгээ

Хүснэгт 6. Эрт сэрэмжлүүлэх үеийн үнэлгээ

Үзүүлэлт	Оноо						
	3	2	1	0	1	2	3
Зүрхний цохилт	-	< 40	40-50	51-100	101-110	111-130	>130
Амьсгалын тоо	-	< 8	-	9-14	15-20	21-30	>30
Хүчилтөрөгчийн ханамж(%)	≤ 91	92-93	94-95	≥ 96			
Биеийн дулаан	-	< 35	-	35-38,4	-	> 38.5	-
Ухаан санаа	-	-	-	Орчин доо харьцаатай	Зөвхөн асуухад хариулна	Зөвхөн асуухад хариулна	Ухаангүй
Шээсний ялгаралт	Шээс ялгарахгүй	< 0,5	0,5-1	> 1 ба <1.5	> 1:5	-	-
Цусны даралт /Систолын/	< 70 хэвийн үзүүлэлтээс	< 50 хэвийн үзүүлэлтээс	< 20 хэвийн үзүүлэлтээс	Хэвийн суурь үзүүлэлтээс +30 хүртэл - 20 хүртэл	< 30 хэвийн үзүүлэлтээс	< 50 хэвийн үзүүлэлтээс	< 80 хэвийн үзүүлэлтээс
Шокийн байдал	Систолын даралтын хэмжээ ≤ 50 мм муб-аас бага болж багасах						

Тайлбар: Үнэлгээ хийхэд үзүүлэлт тус бүрээр оноо өгч нийлбэр оноогоор тооцно. Дээрх хүснэгт дэх 0 оноо нь хэвийн ба суурь үнэлгээний үзүүлэлт болно.

Жишээ нь: тухайн хүн өлсгөлөн зарлахаас өмнө эрүүл мэндийн байдалдаа үнэлгээ хийлгэхэд систолын даралт нь 140 мм.муб байсан бол тэр үзүүлэлтийг суурь даралт гэж үзнэ. Хүснэгтийн 0 онооны хэсэгт цусны систолын даралт +30-аас -20 хүртэл хэлбэлзэхэд "хэвийн" гэж үзнэ. Энэ нь тухайн хүний цусны систолын даралтын суурь хэмжээ нь 140 мм.муб + 30 мм.муб = 170 мм.муб, 140 мм.муб - 20 мм.муб = 120 мм.муб болбол "хэвийн" гэж үзнэ.

Харин 140 мм.муб -70 мм.муб = 70 мм.муб даралт унаж байна гэж үзэн 3 оноо өгнө. Эсвэл 140 мм.муб +80 мм.муб = 220 мм.муб болбол даралт ихдэж байна гэж үзэн 3 оноо өгнө.

Гурав. Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн байгууллагын гүйцэтгэх үүрэг

3.1.Өлсгөлөн зарлагчийн хүсэлтийг үндэслэн Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн нэгдсэн эмнэлэг, орон нутгийн цагдан хорих байрны эмч нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан журмын дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, энэ журмын 2.5 дахь заалтад заасны дагуу суурь үнэлгээ хийж, өлсгөлөн зарлахад харшлах өвчин байгаа эсэхийг тодорхойлж, гарсан дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

3.2.Өлсгөлөн зарлагчид эрүүл мэндэд хяналт тавьж буй эмч нь "Эрт

сэрэмжлүүлэх үнэлэмжийн хүснэгт"-ийн дагуу үнэлгээг хийж, нийлбэр оноо 4 буюу түүнээс дээш үнэлэгдсэн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өлсгөлөнг зогсоох талаар өлсгөлөн зарлагчид өөрт нь шууд, харин түүний хууль ёсны өмгөөлөгч, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүн болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд цагдан хорих байрны удирдлагаар уламжлуулан даруй мэдэгдэж, шаардлагатай гэж үзвэл албадан эмчилгээнд хамруулж, өдөрт 8 цаг тутам хяналтын үзлэг хийж, бүртгэл хөтөлнө.

3.3.Өлсгөлөн зарлагчийн эрүүл мэндийн байдал хүндэрч, албадан хооллох, албадан эмчилгээнд зайлшгүй орох шаардлагатай тохиолдолд Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан журмын дагуу Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид тус ангийн эмнэлэгт, орон нутгийн цагдан хорих байранд тухайн нутаг дэвсгэрийн эмнэлгийн байгууллагад шилжүүлэн албадан эмчилнэ.

3.4.Өлсгөлөн зарлагчид амин чухал эрхтний үйл ажиллагааг дэмжих, хамгаалахаар судсаар хордлого тайлах шингэн, тэжээлийн уураг, амин хүчил, эрдэс бодис зэрэг дусал, эм тариаг хэрэгцээт хэмжээгээр биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэхгүйгээр албадан эмчилгээ хийнэ.

3.5.Өлсгөлөн зарлагчид Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан "Хоол эмчилгээний удирдамж"-ын 8 дахь заалтыг баримтлан шулуун гэдсээр бургуйгаар тэжээлийн уураг, амин хүчил, эрдэс бодис, тараг, зутан, бантан хоолыг өдөрт 2-оос доошгүй удаа 500 грамм хэмжээтэй биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэхгүйгээр албадан хийнэ.

3.6.Өлсгөлөн зарлагч албадан эмчилгээ хийлгэх, албадан хооллолтоос татгалзсан тохиолдолд "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг" маягыг бичүүлж гарын үсэг зуруулна.

3.7.Амь тэнссэн байдлаас бусад тохиолдолд өлсгөлөн зарласан газар, байршил, эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлага хангахгүй нөхцөлд эмчилгээ хийхийг хориглоно.

3.8.Өлсгөлөн зарлагч эмчилгээ, шинжилгээ хийсэнтэй холбогдон гарсан зардлыг өвчний түүх болон эрүүл мэндийн хяналтын хуудсанд тэмдэглэн зохих хууль, тогтоолын дагуу шийдвэрлэнэ.

3.9.Өлсгөлөн зарлагчийн биеийн эрүүл мэндийн байдал хүндэрч, төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусламж, үйлчилгээ шаардлагатай тохиолдолд Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан журмыг баримтлан ажиллана.

Дөрөв. Өлсгөлөн зарласан үед цагдан хорих байрны захиргааны гүйцэтгэх үүрэг

4.1.Хоригдсон, баривчлагдсан этгээд цагдан хорих байранд өлсгөлөн зарласан тохиолдолд "Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль"-ийн 36 дугаар зүйл, "Хорих байрны дотоод журам"-ын 16 дахь хэсэгт заасныг баримтална.

4.2.Өлсгөлөн зарлагчид энэхүү зааврын дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ

үзүүлэхэд ээлжийн дарга, харуул хамгаалалтын ажилтан нь эмч, эмнэлгийн ажилтны аюулгүй байдлыг хангана.

4.3.Өлсгөлөн зарлахад харшлах өвчтэй нь тогтоогдсон боловч өлсгөлөн зарлаж биеийн эрүүл мэндийн байдалд эрсдэл үүсэх тохиолдолд эмч нарын дүгнэлтийн дагуу албадан хооллох, албадан эмчилгээнд хамруулах ажлыг энэ зааврын дагуу зохион байгуулна.

4.4.Өлсгөлөн зарлагчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг харгалзан Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан "Нийгэмд аюултай үйлдэл хийж болзошгүй сэтгэцийн эмгэгтэй хүнд хэрэглэх тусгаарлах болон номхотгох аргын жагсаалт, тэдгээрийг хэрэглэх журам"-д заасныг баримталж ажиллана.

4.5.Өлсгөлөн зарлагчийн биеийн байдлын өөрчлөлт, эмч нарын дүгнэлтийг тухай бүр цагдан хорих байрны удирдлага хяналт тавьж буй эрх бүхий албан тушаалтанд бичгээр танилцуулна.

--oOo--

Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 16.1.140 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАХАД ХАРШЛАХ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өлсгөлөн зарлагчийн эрүүл мэндийн байдлыг тогтоох зорилгоор үзлэг, шинжилгээнд хамруулахад дараах өвчин, эмгэг илэрвэл өлсгөлөн зарлахыг хориглоно.

Хоёр. Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт

- 2.1. Сүрьеэ болон бусад халдварт өвчин;
- 2.2. Элэгний өвчин /элэгний идэвхт архаг үрэвсэл, элэгний хатуурал, элэгний дутмагшил/;
- 2.3. Бүх төрлийн хавдрын өвчнүүд;
- 2.4. Зүрх судасны өвчин /зүрхний цочмог ба архаг дутмагшил, зүрхний цус хомсдолын цочмог ба архаг өвчин, артерийн даралт ихсэлтийн 2-р зэрэг, артерийн даралт багасах, зүрхний хүнд хэлбэрийн хэм алдагдал, хүндрэл бүхий зүрхний төрөлхийн ба олдмол гажиг/;
- 2.5. Дотоод шүүрлийн булчирхайн өвчин /хордлогот бахлуур, тулай, чихрийн шижин, бөөрний дээд булчирхайн цочмог ба архаг дутмагшилт өвчнүүд, тураалын 2-р зэрэг/;
- 2.6. Цусны өвчин, цус багадалт;
- 2.7. Хоол боловсруулах замын өвчин /ходоодны шархлаа, нарийн болон бүдүүн гэдэсний шархлаа, нойр булчирхайн архаг үрэвсэл/;
- 2.8. Бөөрний өвчин /бөөрний хурц болон архаг үрэвсэл, дутмагшил/;
- 2.9. Мэс заслын өвчнүүд /хурц болон архаг үед/;
- 2.10. Сэтгэцийн өвчний хямрал /Тэнэгрэл, органик шалтгаантай сэтгэл хөдлөлийн эмгэг, органик шалтгаантай солиорол, архины шалтгаант солиорол, тархины өвчин, гэмтэл, үйл ажиллагааны шалтгаант бие хүний ба зан төрхийн бусад органик эмгэгийн сэдрэлийн үе, шизофрени болон шизофренийн хүрээний эмгэг, сэтгэл цочирдлын эмгэгийн сэдрэлийн үе, мэдрэлийн гаралтай хоолонд дургүй болох эмгэг, оюуны хомсдол/
- 2.11. Мэдрэлийн гаралтай өвчин /уналт таталт, тархины гэмтлийн болон цус харвалтын дараах үлдэц/
- 2.12. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин /уушгины хурц болон архаг үрэвсэл, багтраат өвчнүүд/

Гурав.Өлсгөлөн зарлахыг хориглох

3.1.Өсвөр насны хүн, өндөр настан /эмэгтэй 55, эрэгтэй 60-аас дээш насны хүн/, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, төрсний дараах болон жирэмслэлт зогссоны дараах 2 сарын хугацаанд өлсгөлөн зарлахыг хориглоно.

3.2.Өлсгөлөн зарласны улмаас биеийн эрүүл мэндэд гарсан өөрчлөлт хэвийн болж тогтворжоогүй, хоол, тэжээл, уураг, эрдэс бодисын дутагдал нөхөгдөөгүй бол дахин өлсгөлөн зарлахыг хориглоно.

--oOo--



ӨЛСГӨЛӨН ЗАРЛАСАН ҮЕД ХӨТЛӨХ МАЯГТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ШАЛТГААНААР ӨЛСГӨЛӨН ЗАРЛАХЫГ ХОРИГЛОСОН ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТЫН КОМИССЫН ДҮГНЭЛТ, ШИЙДВЭР

Хоригдогчийн овог нэр.....

Нас Хүйс Цагдан хорих байрны өрөөний дугаар

Биеийн жин өндөр БЖИ

Зовуурь

Үзлэг

Сэтгэцийн эмчийн үзлэг

Шинжилгээ:

Цусны ерөнхий шинжилгээ

Шээсний ерөнхий шинжилгээ.....

Биохимийн шинжилгээ.....

Бусад

Онош

Эмчийн дүгнэлт, шийдвэр

Эмчийн нэр /..... /

/гарын үсэг/

огноо

ХОРИГДОГЧИД ӨГӨХ АНХААРУУЛГА

I.Өлсгөлөн зарласантай холбоотойгоор биед илрэх сөрөг нөлөө:

1.Төв мэдрэлийн системийн талаас: Нойргүйдэх, сэтгэл санааны өөрчлөлт үүсэх, толгой өвдөх, толгой эргэх, нүд харанхуйлах, хөдөлгөөний тэнцвэр алдах г.м

2.Зүрх судасны системийн талаас: Артерийн даралт буурах, ихсэх, зүрхний хэм алдагдах, цээжээр хатгуулж өвдөх, захын эрхтэнд цусан хангамжийн дутагдал үүсэх г.м.

3.Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны талаас: Цээж гашуун оргих, гэдэс дүүрэх, хэвлийгээр хүчтэй өвдөх г.м.

4.Бөөр, шээс дамжуулах системийн талаас: Хавагнах, шээс өтгөн, эхүүн үнэртэй гарах /бөөрний архаг үрэвсэл хурц үрэвсэлд шилжих/, шээсний сүвээр хатгуулж, хорсож өвдөх, шээс хаагдах, ууц нуруугаар чилж өвдөх, хэвлийн доод хэсгээр хүчтэй өвдөх, шинж тэмдэг илэрнэ.

II.Өлсгөлөн зарласантай холбоотойгоор биед илрэх эргэшгүй өөрчлөлт, өвчний хүндрэл:

1. Бөөрний дутагдалд орох /бөөр үхжих/;
2. Артерийн даралт ихсэж, багассанаас тархинд цус харвалт үүсэх;
3. Зүрхний шигдээс үүсэх;
4. Ходоодны шарх үүсэх;
5. Цөсний чулуу үүсэх;
6. Бөөрний чулуу үүсэх;
7. Хөл, гар мэдээгүй болох, саа саажилт үүсэх;
8. Зүрх гэнэт зогсох.

Эмнэлгийн хяналтын комиссын дүгнэлт, шийдвэр

Комиссын дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч даргын нэр.....

Гишүүд: Дотрын их эмчийн нэр

Хариуцсан эмчийн нэр

Бусад төрөлжсөн мэргэшлийн эмчийн нэр

/гарын үсэг/

огноо

Танилцсан: Хоригдогчийн овогнэр/...../

/гарын үсэг/

огноо

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Өлсгөлөн зарлагчийн овог нэр.....

Нас хүйс Цагдан хорих байрны ерөөний дугаар

Өлсгөлөн зарлахаас өмнөх биеийн жин өндөр БЖИ

Зовуурь

.....

Үзлэг

.....

.....

Сэтгэцийн эмчийн үзлэг

.....

.....

Шинжилгээ:

Цусны ерөнхий шинжилгээ

.....

Шээсний ерөнхий шинжилгээ.....

.....

Биохимийн шинжилгээ.....

.....

Бусад

.....

Онош

.....

Эмчийн дүгнэлт, шийдвэр

.....

.....

Эмчийн нэр /..... /

/гарын үсэг/

огноо

Гэдэс цэвэрлэх бургуй тавьсан

Ажилтны нэр /..... /

/гарын үсэг/

Өлсгөлөн зарласан цаг хугацаа:

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАГЧИД ӨГӨХ АНХААРУУЛГА

I. Өлсгөлөн зарласантай холбоотойгоор биед илрэх сөрөг нөлөө:

1. Төв мэдрэлийн системийн талаас: Нойргүйдэх, сэтгэл санааны өөрчлөлт үүсэх, толгой өвдөх, толгой эргэх, нүд харанхуйлах, хөдөлгөөний тэнцвэр алдах г.м
2. Зүрх судасны системийн талаас: Артерийн даралт буурах, ихсэх, зүрхний хэм алдагдах, цээжээр хатгуулж өвдөх, захын эрхтэнд цусан хангамжийн дутагдал үүсэх г.м
3. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны талаас: Цээж гашуун оргих, гэдэс дүүрэх, хэвлийгээр хүчтэй өвдөх г.м
4. Бөөр, шээс дамжуулах системийн талаас: Хавагнах, шээс өтгөн, эхүүн үнэртэй гарах /бөөрний архаг үрэвсэл хурц үрэвсэлд шилжих/, шээсний сүвээр хатгуулж, хорсож өвдөх, шээс хаагдах, ууц нуруугаар чилж өвдөх, хэвлийн доод хэсгээр хүчтэй өвдөх шинж тэмдэг илэрнэ.

II. Өлсгөлөн зарласантай холбоотойгоор биед илрэх эргэшгүй өөрчлөлт, өвчний хүндрэл:

1. Бөөрний дутагдалд орох /бөөр үхжих/;
2. Артерийн даралт ихсэж, багассанаас тархинд цус харвалт үүсэх;
3. Зүрхний шигдээс үүсэх;
4. Ходоодны шарх үүсэх;
5. Цэсний чулуу үүсэх;
6. Бөөрний чулуу үүсэх;
7. Хөл, гар мэдээгүй болох, саа саажилт үүсэх;
8. Зүрх гэнэт зогсох.

III. Бусад:

1. Өлсгөлөн зарлагч нь эмчийн үзлэгт өдөр бүр хамрагдаж, шаардлагатай тохиолдолд лабораторийн болон багажийн шинжилгээнд хамрагдана.
2. Биеийн ерөнхий байдал хүндэрч амин үзүүлэлт тогтворгүй болсон үед эмчийн шийдвэрээр албадлагын арга хэмжээ авч өлсгөлөнг зогсоож, албадан эмчилгээнд хамруулна.

Танилцсан: Өлсгөлөн зарлагчийн овог нэр/...../
/гарын үсэг/

ОГНОО

ӨДӨР ТУТМЫН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ

Д/д	Огноо	Зовуурь	Амин үзүүлэлтүүд				Биеийн жин /кг/	Үзлэг хийсэн эмчийн гарын үсэг
			Артерийн даралт /мм.муб/	Зүрхний цохилт /тоо/	Цусан дахь хүчил төрөгчийн хэмжээ /%/	Биеийн хэм /t°/		
1								
2								
3								
4								
5								
6								
7								

Давтан хийгдсэн шинжилгээний өөрчлөлт:

Цусны ерөнхий шинжилгээ.....

Шээсний ерөнхий шинжилгээ.....

Биохимийн шинжилгээ.....

Бусад.....

Өгсөн зөвлөгөө, зөвлөмж:

Онош.....

Эмчийн дүгнэлт, шийдвэр:.....

Эмчийн нэр /...../
/гарын үсэг/

огноо

Танилцсан: Өлсгөлөн зарлагчийн овог нэр /...../
/гарын үсэг/

огноо

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАГЧИД АЛБАДАН ЭМЧИЛГЭЭ, АЛБАДАН ХООЛЛОЛТ
ХИЙХ ЭМНЭЛГИЙН ХЯНАЛТЫН КОМИССЫН ДҮГНЭЛТ, ШИЙДВЭР

Өлсгөлөн зарлагчийн овог нэр.....

Нас Хүйс Цагдан хорих байрны өрөөний дугаар

Биеийн жин өндөр БЖИ

Зовуурь

.....

.....

Үзлэг

.....

.....

.....

Сэтгэцийн эмчийн үзлэг

.....

Шинжилгээ:

Цусны ерөнхий шинжилгээ

.....

Шээсний ерөнхий шинжилгээ

.....

Биохимийн шинжилгээ

.....

Бусад

.....

Онош

.....

.....

Эмчийн дүгнэлт, шийдвэр

.....

.....

Эмчийн нэр /..... /

/гарын үсэг/

огноо

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАГЧИД ӨГӨХ АНХААРУУЛГА

I. Өлсгөлөн зарласантай холбоотойгоор биед илрэх сөрөг нөлөө:

1. Төв мэдрэлийн системийн талаас: Нойргүйдэх, сэтгэл санааны өөрчлөлт үүсэх, толгой өвдөх, толгой эргэх, нүд харанхуйлах, хөдөлгөөний тэнцвэр алдах г.м
2. Зүрх судасны системийн талаас: Артерийн даралт буурах, ихсэх, зүрхний хэм алдагдах, цээжээр хатгуулж өвдөх, захын эрхтэнд цусан хангамжийн дутагдал үүсэх г.м
3. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны талаас: Цээж гашуун оргих, гэдэс дүүрэх, хэвлийгээр хүчтэй өвдөх г.м
4. Бөөр, шээс дамжуулах системийн талаас: Хавагнах, шээс өтгөн, эхүүн үнэртэй гарах /бөөрний архаг үрэвсэл хурц үрэвсэлд шилжих/, шээсний сүвээр хатгуулж, хорсож өвдөх, шээс хаагдах, ууц нуруугаар чилж өвдөх, хэвлийн доод хэсгээр хүчтэй өвдөх, шинж тэмдэг илэрнэ.

II. Өлсгөлөн зарласантай холбоотойгоор биед илрэх эргэшгүй өөрчлөлт, өвчний хүндрэл:

1. Бөөрний дутагдалд орох /бөөр үхжих/;
2. Артерийн даралт ихсэж, багассанаас тархинд цус харвалт үүсэх;
3. Зүрхний шигдээс үүсэх;
4. Ходоодны шарх үүсэх;
5. Цэсний чулуу үүсэх;
6. Бөөрний чулуу үүсэх;
7. Хөл, гар мэдээгүй болох, саа саажилт үүсэх;
8. Зүрх гэнэт зогсох.

Эмнэлгийн хяналтын комиссын дүгнэлт, шийдвэр

.....
.....
.....

Комиссын дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч даргын нэр

Гишүүд: Дотрын их эмчийн нэр

Хариуцсан эмчийн нэр

Бусад төрөлжсөн мэргэшлийн эмчийн нэр

/гарын үсэг/

огноо

Танилцсан: Өлсгөлөн зарлагчийн овог нэр /

/гарын үсэг/

огноо

ӨЛСГӨЛӨН ЗОГСООХ ҮЕИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ

Өлсгөлөн зарлахаас өмнөх биеийн жин өндөр БЖИ

Одоогийн биеийн жин жингийн алдагдал

Өлсгөлөнг зогсоосон /огноо цаг хугацаа/

Зовуурь

Үзлэг

Сэтгэцийн талаас гарах өөрчлөлт.....

Онош

Эмчийн дүгнэлт, шийдвэр

Эмчийн нэр / /
/гарын үсэг/

огноо

ӨЛСГӨЛӨН ЗАРЛАГЧИД ӨГӨХ АНХААРУУЛГА

I. Өлсгөлөн зарласантай холбоотойгоор “дахин хооллолтын хам шинж” илэрч болзошгүй.

1. Өлсгөлөнгийн байдалд удаан хугацаагаар байсны дараа хоол, тэжээл хэрэглэхтэй холбоотой илрэх бодисын солилцооны өөрчлөлт илэрч болно.

2. Олон эрхтний дутагдал ялангуяа, бөөрний дутагдалд орж болно.

3. Огиулж, бөөлжих, нойрмоглох, амьсгал, зүрх судасны дутагдал, гипотензи, хэм алдагдал, ухаан самуурах зэрэг шинж тэмдэг илэрч комын байдалд орж үхэлд хүрч болно.

II. Зөвлөмж

1. Өлсгөлөн зогсоосны дараа эмчийн үзлэгт өдөр бүр хамрагдаж, шаардлагатай тохиолдолд давтан лабораторийн болон багажийн шинжилгээнд хамрагдах.

2. Эмчийн зөвлөмжийн дагуу хоол, ундны дэглэм барьж хоол идэх

Танилцсан: Өлсгөлөн зарлагчийн

овог нэр / /
/гарын үсэг/

огноо

---oOo---